



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2025 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

Их эв намын даргаар бүртгүүлэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Танхимын тэргүүн Г.Алтанчимэг даргалж, шүүгч Б.Амарбаясгалан, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Г.Банзрагч, М.Батсуурь, Н.Баярмаа, Н.Батчимэг, Н.Батзориг, Ц.Оч, Э.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар, Их эв намын даргаар З.Бат-Отгоныг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Б.Амарбаясгалангийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Их эв намын үүсгэн байгуулагч З.Бат-Отгоноос 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Улсын дээд шүүхэд гаргасан өргөдөлдөө: “Намын 2025 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит бус II Их хурлаар намын даргыг сонгох нууц санал хураалт явуулж, нийт хурлын төлөөлөгчдийн 93.8 хувийн саналаар З.Бат-Отгон сонгогдсон тул намын даргаар бүртгэж өгнө үү” гэж, нийт 145 хуудас материал, 2 ширхэг сиди, 115 саналын хуудасны хамт ирүүлсэн, өргөдлийг шалгах ажиллагааны явцад 98 хуудас баримтыг нэмэлтээр ирүүлжээ.

Дээрх өргөдөл, холбогдох баримтуудыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын дагуу шалгаж, нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцсэн болно.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дараах үндэслэлээр Их эв намын даргаар З.Бат-Отгоныг бүртгэж шийдвэрлэлээ.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Намын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог энэ хуульд заасны дагуу намын дүрмээр зохицуулна”, 15.2-т “Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана:” гээд 15.2.4-т “намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллага болон бусад байгууллага, тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ, хуралдуулах, шийдвэр гаргах журам”, 15.2.5-д “намын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, түүний бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ”, 17 дугаар зүйлийн

17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” гээд 17.2.4-д “Намын дүрэмд заасан бусад асуудал”, 17.6-д “Намын дүрэмд заасны дагуу намын даргыг удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага, ... сонгоно” гэж тус тус заажээ.

Их эв намын 2025 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит бус II Их хурлаас намын даргыг сонгосон үйл ажиллагаа нь хуулийн дээрх зохицуулалт болон Улсын дээд шүүхэд бүртгэлтэй тухайн намын дүрэмд нийцсэн байна.

Нэг.Намын удирдах дээд байгууллагыг зарлан хуралдуулсан процессын талаар:

Их эв намын дүрмийн 6.3.3-т “Намын ээлжит бус их хурлыг намын Бага хурлын нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар Их хурал хуралдахаас 21-ээс доошгүй хоногийн өмнө зарлаж, хуралдуулна”, 6.4.4-т “Бага хурлын хуралдааны товыг уг хурал болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө намын дарга эсвэл удирдах зөвлөл зарлана. Бага хурлын ээлжит бус хурлын товд дээрх хугацаа хамаарахгүй”, 6.4.7.17-д “Намын ээлжит болон ээлжит бус их хурал хуралдуулах тов, хэлэлцэх асуудлыг тогтоох” эрхийг Бага хурал хэрэгжүүлэхээр тус тус заажээ.

Өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтаас үзэхэд Их эв намын Удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 01 дүгээр тогтоолын дагуу төлөөллийн төв байгууллага болох Бага хурал 2025 оны 03 дугаар сарын 09-ний өдөр хуралдаж, улмаар намын ээлжит бус II Их хурлыг 2025 оны 10 дугаар сарын 05-ны өдөр хуралдуулахаар 01 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн нь дээрх дүрмийн заалтад нийцэж байна.

Их эв намын ээлжит бус II Их хурлыг товлон зарлах болон хурлын товыг намын гишүүд, төлөөлөгчдөд намын фэйсбүүк хуудсаар 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр, Өнөөдөр сонины 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 159 дүгээр дугаарт нийтлэн хүргэсэн болох нь тогтоогдсон.

Хоёр. Намын даргыг сонгосон тухайд:

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.3-т “Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагын болон намын бусад хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх, цөөнхийн саналыг хэлэлцэх боломж олгож хүндэтгэн үзэх бөгөөд тодорхой асуудлыг дийлэнх олонхын саналаар шийдвэрлэхээр намын дүрэмд зааж болно”, 17 дугаар зүйлийн 17.6-д “Намын дүрэмд заасны дагуу намын даргыг удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага, ... сонгоно” гэж;

Их эв намын дүрмийн 1.8.3-т “Намын удирдах шатны байгууллагыг сонгож байгуулах бөгөөд бүх шатны сонгуульд нэр дэвшүүлэх, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхдээ сонгон шалгаруулалтын үндсэн дээр үйл ажиллагааг ил тод, нээлттэй, чөлөөт өрсөлдөөний зарчмаар явуулж, саналыг нууцаар хураах”, 4.3.1-д “Их эв намын удирдах дээд байгууллага нь Намын их хурал мөн”, 6.1-д “Намын бүх шатны байгууллага, гишүүд аливаа асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхдээ цөөнхийн саналыг хүндэтгэлтэй сонсож, олонхын шийдвэр гарган, нийтээрээ дагаж мөрдөх нэгдмэл зарчмыг баримтална”, 4.3.5-д “намын удирдлага” гэдгийг намын дарга, намын ерөнхий нарийн бичгийн дарга, нийслэлийн намын дарга гэж ойлгоно”, 6.3.1-

д “Намын Их хурал нь 100-аас доошгүй төлөөлөгчөөс бүрдэнэ. Төлөөлөгчдийн 50 хүртэл хувь нь эмэгтэй төлөөлөгч байна”, 6.3.4-т “Намын их хурал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”, 6.3.4.2-т “Намын даргыг сонгох”, 6.7.1-д “Намын даргыг намын их хурлаас сонгох бөгөөд бүрэн эрхийн хугацаа 4 жил байх ба 2 удаа улиран сонгогдох эрхтэй ...” гэж тус тус заасан.

Өргөдөлд хавсарган ирүүлсэн тус намын ээлжит бус II Их хурлын 2025 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, 02, 03 дугаар тогтоол, Мандатын комиссын 01 дүгээр тогтоол, ирцийн бүртгэл, хурлын явцыг баталгаажуулсан дүрс бичлэг, фото зураг, түүврийн аргаар авсан судалгаа зэрэг баримтуудаас үзэхэд, тухайн намын ээлжит бус II Их хурлын 2025 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанд 114 төлөөлөгч оролцсоноос эрэгтэй 50 (43.8%), эмэгтэй 64 (56.2%), эдгээрийн 106 нь нийслэл, 8 нь орон нутгийн төлөөлөл оролцсон байна.

Өмнө нь “Их эв намын даргаар З.Бат-Отгоныг бүртгүүлэх” өргөдлийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор “намын даргыг сонгохдоо нууц санал хураалтаар шийдвэрлэхээр байхад илээр санал хураасан” гэх үндэслэлээр бүртгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байх бөгөөд тухайн зөрчил арилжээ. Тодруулбал,

Их эв намын ээлжит бус II Их хурлын тэмдэглэлээс үзэхэд, намын даргын сонгуульд З.Бат-Отгон, Н.Эрдэнэдалай, Р.Баярмаа нарын нэрийг дэвшүүлсэн ба төлөөлөгч Р.Баярмаа нэрээ татан авч, З.Бат-Отгон, Н.Эрдэнэдалай нар өрсөлдсөн байх бөгөөд ээлжит бус II Их хурлын Тооллогын комиссын 2025.10.05-ны өдрийн 05 дугаар тогтоолоор нууц санал хураалтын дүнг үндэслэн Их хурлын төлөөлөгчдийн 93.8%-ийн санал авсан З.Бат-Отгоныг намын даргаар сонгогдсон гэж үзэж, Их хурлаар батлуулахаар тогтоосон. Үүнд: Зулаагийн Бат-Отгон 107 санал буюу 93.8%, Норсонжавын Эрдэнэдалай 7 санал буюу 6.2%-ийн санал авсныг баталжээ. Энэ талаарх өргөдөлд хавсарган ирүүлсэн саналыг хуудсыг шалгахад, ямар нэгэн зөрчилгүй байна.

Их эв намын ээлжит II Их хурлын 2025 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 07 дугаар тогтоолоор дээрх Тооллогын комиссоос гаргасан шийдвэрийг үндэслэн, олонхын санал авсан З.Бат-Отгоныг намын даргаар сонгосон, энэ тохиолдолд тус намын Их хуралд нийт 114 гишүүн оролцсоноос 93.8%-ийн саналаар дээрх шийдвэрийг гаргасан нь Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.3, намын дүрмийн 1.8.3, 6.1, 6.7.1-д заасантай нийцжээ.

Дээрх үндэслэлээр Их эв намын даргаар З.Бат-Отгоныг бүртгэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.6-д заасныг баримтлан Их эв намын даргаар Зулаагийн Бат-Отгоныг бүртгэсүгэй.

2.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.5-д зааснаар Улсын дээд шүүхийн энэхүү шийдвэр нь эцсийн болохыг дурдсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Г.АЛТАНЧИМЭГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Б.АМАРБАЯСГАЛАН